

**УЛС ТӨРИЙН ИНСТИТУТ БА ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ: ХАРЬЦУУЛСАН
СУДАЛГАА⁸³**

Ж.Төртогтох доктор, дэд профессор
МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Ч.Өлзийсайхан доктор, дэд профессор
МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Б.Эрдэнэдалай докторант

Улс төрийн институтэд итгэх итгэлийн судалгааны арга зүй

Өрнөдийн болон бусад хөгжингүй ардчиллын системд төр засаг, улс төрийн институтуудад итгэх олон нийтийн итгэл 20-р зууны хоёрдугаар хагасаас, тухайлбал 1960-аад оноос хойш буурч ирсэн байдаг. Нийгмийн шинжлэх ухааны олон салбарууд ялангуяа улс төрийн шинжлэх ухааны ахисан түвшний бие даасан болон салбар дундын, харьцуулсан болон нэгтгэсэн олонх судалгааны үр дүнгүүд ерөнхий хоёр асуудалд голчлон анхаарч энэ үзэгдлийг тайлбарлах оролдлого хийж ирсэн билээ. Бидний судалгааны агуулга ч мөн адил тэдгээр үр дүн, тайлбарыг анхааран үзэж, судалгааны арга зүйн нэгэн чухал бүрэлдэхүүн болгон авч үзэж байгаа юм. Эхний бүлэг судалгаа нь төр засагт итгэх олон нийтийн итгэл бол эдийн засгийн хүчин зүйлийн функц, гэмт хэрэг, ядуурал гэх мэт нийгмийн бодитой нөхцөл байдал болон сонгогдсон улс төрийн албан тушаалтнууд ба төрийн институтуудын ажил үүргээ хэрхэн биелүүлж буй талаарх үнэлгээ зэрэг улс төрийн хүчин зүйлс хэмээн авч үзэж байна. Тэгвэл судалгааны нөгөө нэг бүлэг дүгнэлт, үр дүнгийн агуулга нь төр засагт итгэх итгэлээр дамжуулан улс төрийн бусад хандлага, үйл байдлыг тайлбарлахад дөхөм болно, тухайлбал, итгэлийн түвшний уналт нь төр засгийн талаарх олон нийтийн үнэлэлт дүгнэлт, санал өгөх шалтгаан зорилго зэрэгт нөлөөлдөг хэмээн авч үздэг. Түүнээс гадна одоогоор бидний судалгааны хүрээнд авч үзэж буй тодорхой хийгдсэн судалгааны агуулга, үр дүнгийн тухайд гэвэл ихэнхдээ төрийн байгууллагуудад итгэх олон нийтийн итгэлийн асуудалд төвлөрч байна.

Иймд бидний судалгааны нэг онцлог бол төр засгийн удирдах дээд байгууллагуудын хувьд олон нийтийн зүгээс үйл ажиллагаанд нь хэрхэн үнэлэлт өгч, ерөнхийдөө хэр зэрэг итгэж буй асуудлыг төвлөрөн судалдаг тэдгээр өрнөдийн

⁸³ МУИС-ийн Орчин үеийн улс төрийн судалгааны төвөөс энэхүү судалгааг 2010-2011 онд Азийн Судалгааны Төвийн санхүүжилттэй хийж гүйцэтгэсэн болно. Төслийн удирдагчаар МУИС-ийн Орчин үеийн улс төрийн судалгааны төвийн эрхлэгч, улс төр судлалын тэнхимийн профессор, доктор Ж.Төртогтох, төслийн судлаачдаар АНУ-ын Нью Йорк мужийн Итака Коллежийн профессор, доктор Томас Шевори, МУИС-ийн улс төр судлалын тэнхимийн дэд профессор, доктор Ч.Өлзийсайхан, МУИС-ийн улс төр судлалын тэнхимийн ахлах багш, докторант Д.Бадамдаш, ХААИС-ийн нийгмийн ухааны тэнхимийн багш, докторант М.Мөнхзул, МУИС-ийн улс төр судлалын тэнхимийн докторант Б.Эрдэнэдалай нар ажиллалаа.

ихэнх судалгааны мөн чанарыг арга зүйн хувьд баримжаа болгон ашиглахын зэрэгцээ итгэлийн талаарх судалгааны цар хүрээг зөвхөн тийм институтээр хязгаарлалгүйгээр улс төрийн бусад институтийн талаарх олон нийтийн итгэлийн асуудлыг хамтад нь нэгтгэн судлахыг оролдсон болно.

Улс төрийн ардчилал, соёлд суралцаж буй орны хувьд Монголын улс төрийн хөгжил улс төрийн институтуудад тулгарч буй бэрхшээл, сорилтоор дамжин өөрчлөгдсөөр ирсэн билээ. Тиймээс улс төрийн институтуудад итгэх олон нийт, сонгогчдын итгэл, дэмжлэг болон улс төрийн хөгжлийн уялдаа холбоог судлах асуудал орчин үеийн улс төрийн ухааны судалгаанд чухлаар тавигдаж буй асуудлын нэг болж байна. Түүнчлэн, улс төрийн хөгжил ба улс төрийн институт хоорондын асуудлыг тусгайлан харьцуулж судалсан судалгаа (ялангуяа улс төрийн институт хоорондын болон улс хоорондын харьцуулалт) дутмаг тал ажиглагдаж байна. Энэхүү судалгааны гол зорилго нь улс төрийн институтуудын зүгээс улс төрийн хөгжилд үзүүлэх үүрэг нөлөөг олон нийтийн зүгээс тэдгээрт итгэж буй итгэлийн хандлагад үндэслэн судлах явдал байсан бөгөөд уг зорилгод хүрэхийн тулд ардчилсан нийгмийн улс төрийн хөгжил дэх улс төрийн институтуудын чиг үүргийг судлах, улс төрийн институтэд итгэх олон нийтийн итгэлийг институт хооронд харьцуулан судлах гэсэн зорилтуудыг дэвшүүлэн тавьсан.

Ардчиллын хөгжлийн ялгаатай түвшнээс үл хамааран олон нийтийн итгэл улс төрийн институтуудын хувьд харьцангуй буурч буй нийтлэг үзэгдэл нь тэдгээрт итгэх итгэлийг нэмэгдүүлэх шаардлагыг нөхцөлдүүлж байгаа юм. Улс төрийн мөргөлдөөнийг зохицуулах (Dunn 1988, Braithwaite 1998, Strompcka 1999, Thompson 2004) төр засгийн чадавхи нь ардчилсан системийн хүч чадлыг сорихын зэрэгцээ олон нийтийн хувьд тийм чадавхид эргэлзэх эсвэл итгэхийн аль тал руу хэлбийж буйг ажиглах бололцоог орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны чиглэлд хандуулж байгаа юм. Хөгжиж буй болон хөгжингүй аль ч орны иргэд тодорхойгүй, эргэлзээтэй, найдваргүй үр дүн бүхий эрх мэдэл хуваарилах улс төрийн тоглолт болж буй нөхцөлд дээрх асуултыг тавьж байдаг. Төр засаг, улс төрийн институтууд тийм ээдрээтэй хямралыг шийдвэрлэж чадах уу? Өөрөөр хэлбэл тэдэнд итгэх бидний итгэл ямар байна вэ?

Улс төрийн шинжлэх ухааны орчин үеийн судалгааны дагнасан өгүүллүүд, тайлангийн агуулгад үндэслэн итгэлийн талаар авч үзье. Дак, Крамер нар итгэлийг хувь хүн хоорондын болон байгууллагын хоорондын нарийн төвөгтэй үзэгдлийн (Duck 1997; Kramer and Tyler 1995) хувьд авч үзсэн бол Вилес, Гроц нар талууд харилцан бие биенээ эрхэмлэх түвшинг барьж энэ харилцаагаа таамаглаж буй үр дүндээ хүрэхэд чиглүүлж байгаа тэр үед итгэл гэдэг зүйл гарч ирнэ (Wheeless and Grotz 1977, 251) хэмээн үзсэн байдаг. Улс төрийн нэр томъёоны хувьд улс төрийн итгэл хэмээх бие даасан ойлголтыг илэрхийлдэг бөгөөд энэ нь төр засаг, түүний институтуудад итгэх иргэдийн үнэлгээг илэрхийлж байдгаараа бидний судалгаанд арга зүйн хувьд чухал ач холбогдолтой юм.

Улс төрийн институтэд итгэх итгэл нь нийгмийн хандлага, улс төрийн үйл байдал, нийгмийн баялаг, засаглал зэрэг ойлголтуудтай нягт холбоотой үзэгдэл юм. Учир нь олон нийтийн итгэлийн талаарх аливаа эмпирик судалгаа явуулж хэмжиж дүгнэх аливаа оролдлого нь нийгэм, эдийн засаг, улс төрийн янз бүрийн түвшний институтийн зүгээс нийгмийн хөгжилд, нийгмийн баялагийг бүтээхэд оруулж буй хувь нэмрийн талаарх иргэдийн үнэлэлт дүгнэлт, тэдний нийгмийн хөгжилд хандах

хандлага төдийгүй улс төрийн үйл байдлын дүр төрхийг ч давхар харуулдаг. Энэ нь цөөнгүй судалгааны дүгнэлтээр илэрсэн байдаг.

Итгэл, улс төрийн итгэлийн хэлбэрүүд

Итгэл гэдэг бол хүмүүс хоорондын болон зохион байгуулалтын хүрээнд тогтдог түгээмэл байдаг харилцаа юм (Duck 1997; Kramer and Tyler 1995). Нэг нэгнийхээ талаар тодорхой таатай сэтгэгдэл бүхий талууд энэ харилцаандаа тулгуурлан хүссэн үр дүнд хүрэх боломжийг нээснээр итгэл бүрэлддэг (Wheless and Grotz 1977, 251). Иргэд төр засгийг болон түүний институцуудыг, бодлого гаргагчдыг, улс төрийн лидерүүдийг амлалтандаа хүрдэг, үр дүнтэй ажилдаг, шударга, үнэнч гэж дүгнэж байгаа үед улс төрийн итгэл байдаг. Өөр үгээр хэлбэл улс төрийн итгэл нь “улс төрийн тогтолцоо болон тэнд байгаа улс төрийн албан тушаалтныг хариуцлагатай, байнгын хяналт тавиагүй байсан үед ч зөв зүйтэй зүйлийг хийдэг гэж иргэд үзэж байгааг хэлнэ” (Miller and Listhaug 1990, 358). Тэгэхээр “улс төрийн итгэл бол олон нийт төрийн бодлогын талаар ямар сэтгэгдэлтэй байгааг гол заагч болно” (Newton and Norris 2000, 53).

Улс төрийн итгэл нь улс төрийн тогтолцоо, түүний байгууллагууд, мөн улс төрийн тодорхой албан тушаалтан руу чиглэдэг. Улс төрийн итгэлд юуны өмнө макро түвшний буюу улс төрийн байгуулалтын итгэл орно. Улс төрийн байгуулалтын талаархи иргэдийн итгэл нь энэ хүрээнд иргэд “бодлогын хувилбаруудад сэтгэл хангалуун эсвэл сэтгэл хангалуун биш байгаагаас болоод” (Miller 1974, 951) төр засагт итгэдэг, эсвэл итгэлээ алддаг байна. Улс төрийн байгуулалтын талаархи итгэлийг дотор нь сарнимал буюу тогтолцоонд суурилсан итгэл, мөн тусгай буюу институцид суурилсан итгэл гэж хуваана. Улс төрийн тогтолцоо болон дэглэм бүхэлдээ хэрхэн ажиллаж байгааг иргэд үнэлсэнийг сарнимал улс төрийн итгэл гэнэ. Улс төрийн тодорхой институцид чиглэсэн итгэлийг тусгай улс төрийн итгэл гэнэ. Хойно тодорхой авч үзэх Монгол дахь улс төрийн институтэд итгэх олон нийтийн итгэлийн талаарх судалгаагаар энэхүү макро түвшний итгэлийг тодруулах зорилго тавьсан.

Улс төрийн итгэлийн хоёр дахь ангилал бол микро түвшиний буюу хувь этгээдэд чиглэсэн улс төрийн итгэл бөгөөд улс төрийн тодорхой нэг лидерт чиглэсэн байна. Хувь этгээдэд чиглэсэн улс төрийн итгэл нь иргэд “тодорхой улс төрийн лидерийн үйл ажиллагааг дэмжих эсвэл үл дэмжиж байгаагаас болоод” (Citrin 1974, 974-75) төр засагт итгэх эсвэл үл итгэхийг хэлнэ.

Улс төрийн итгэл нь тодорхой асуудлууд дээрх намын харьяалал ба үзэл суртлын хүрээнээс хальдаг. Хетерингтон “төрд итгэх итгэл нь өөрөө төр засгийн бодлогод үзүүлэх дэмжлэгийг урьдаас заагч биеэ даасан чухал үзүүлэлт болоод байгаа бөгөөд намын харьяалал болон үзэл суртлын аль алианаас нь илүү чухал байна” гэжээ (Hetherington 2004). Уоррен “өөрийн сонирхолд хүрэх зорилготой нэгдүгээр эрэмбийн буюу хамгаалалтын улс төрийн итгэл бол улс төрийн жинхэнэ итгэл байхад хангалтгүй” гэжээ. Тэрээр ухаанаар тунгаасан улс төрийн итгэлийг түүнээс дутуугүй, бүр илүү чухал өөр нэгэн төрлийн улс төрийн итгэл болох сэтгэлзүйн буюу хоёрдугаар эрэмбийн улс төрийн итгэлээс хамааралтай байна гэсэн. Сэтгэлзүйн улс төрийн итгэл тодорхой төр засаг, улс төрийн байгуулал, улс


төрийн лидерүүдтэй холбоотой ёс суртахууны үнэ цэнэ, шинж чанарыг үнэлсэн байдал юм. Тэгэхээр энэ нь хүмүүс улс төрийн төлөөллийнхөө итгэл даах байдлыг харж байгааг хэлнэ. Сэтгэлзүйн учир шалтгаанд тулгуурласан улс төрийн итгэлийн үед хүмүүс улс төрийн лидерүүдийн зан төлөв, олон нийтийн өмнөх дүр төрх, хэлсэн үг, зан араншин зэргээс чин сэтгэл, үнэнч чанарыг олж харахыг эрэлхийлдэг.

Нийгмийн итгэл, улс төрийн итгэл хоёрын харилцан хамаарлын талаар ном зохиолуудад маргаантай тусгагдсан байдаг. Нийгмийг баялаг ба нийгмийн итгэл нь улс төрийн итгэлийг тэтгэдэг юм уу, эсвэл улс төрийн итгэл нь тэдгээрийг тэтгэдэг үү, итгэл даасан төр засаг нийгмийн баялгийг хөхүүлж нийгмийг итгэл үзүүлэх, идэвхтэй байхад хүргэдэг үү, үр дүнтэй, удаан хугацаанд тогтох улс төрийн тогтолцоог бий болгохын тулд нийгмийн итгэл ба улс төрийн итгэл хоёрын уулзвар нь юу байна вэ зэрэг асуултуудад онолын сургуулиуд өөр өөр байдлаар хариулсан байна. Жишээлбэл, Алмонд ба Верба болон Финифтер зэрэг (Almond and Verba 1963) Finifter (1970) модернизацийн онолчид үзэхдээ нийгмийн итгэл нэмэгдэх нь улс төрийн оролцоо нэмэгдсэнтэй холбоотой, ялангуяа сонгуульд санал өгөх идэвхи нэмэгдсэнтэй холбоотой гэдэг. Оролцоо нэмэгдэх нь эргээд улс төрийн итгэл ба ардчилалтай байгаагийн ерөнхий шинж тэмдэг болно. Нөгөө талаас социологич нар нийгмийн итгэл биш харин нийгмийн үл итгэх байдал нэмэгдэж байгааг улс төрийн илүү идэвхтэй хөдөлгөөнтэй холбож үзэн, энэ нь эцэстээ улс төрийн итгэл сайжирахад хүргэнэ гэдэг байна. Тухайлбал Тарроу нийгмийн эсэргүүцэл нэмэгдэх, нийгмийн шинэ хөдөлгөөнүүд үүсэх хэлбэрээр илэрч буй улс төрийн маргаантай байдал нь аж үйлдвэржсэн ардчилсан орнуудад итгэлийн асуудал явагдаж байгаа шинж дохио болдог гэж хүртэл баталсан байдаг (Tarrow 2000).

Улс төрийн итгэлийн түвшин, зүй тогтлын талаарх судалгааны үр дүнгийн харьцуулалт

1960-аад онуудын дунд үеэс төр засаг болоод улс төрийн институциудад үзүүлэх олон нийтийн итгэл өндөр хөгжилтэй, ардчилсан орнуудад бүгдэд нь буурч ирсэн. Хэдийгээр зүй тогтол, бууралтын хурд зэрэг нь улс орнуудад харилцан адилгүй байгаа ч буурч байгаа гэдэг нь хаа сайгүй мэдрэгдэх болжээ. Ганц 1970-аад оноос 1990-ээд онуудын дунд үе хүртэл төрд итгэх итгэл нэмэгдэж явсан Нидерланд улсыг эс тооцвол өндөр хөгжилтэй, аж үйлдвэржсэн бүх ардчилсан орнуудад төр засагтаа ард түмний зүгээс үзүүлж буй итгэлийн түвшин буурсан нь тэмдэглэгдсэн. Австричууд хоршоолох үйл ажиллагаа амжилтгүй болсон явдлыг төр засагт итгэх итгэл буурсантай холбож тайлбарлажээ. Канадчууд улс оронд үндсэрхэг үзэл, салан тусгаарлах үзэл хурцадмал байдал руу орсон явдалд бурууг тохсон. Германчууд итгэлээр доройтсон явдлаа хоёр герман нэгдэх явдал хурцаар тавигдаж төр засаг үүнийг шийдэж чадахгүй байсантай холбодог бол Япончууд ар араасаа тохиолдсон улс төрийн жигшүүрт хэргүүд болон 1990-ээд онуудад удаан үргэлжилсэн эдийн засгийн хямралтай холбож үзсэн байдаг. Улс төрд ерөнхийдөө өндөр түвшиний итгэл үзүүлдэг швед, норвегичууд хүртэл 1990-ээд онуудад улс төрийн институтууддээ итгэдэггүй болсон байв. Бүдүүвч 1-ээс Шинэ Зеланд, АНУ зэрэг улсад итгэл буурсан зүй тогтлыг харж болно (Bok 1997). Энэ нь тэдгээр аж үйлдвэржсэн орнуудад хандлага ямар байсныг төсөөлөхөд тус болох юм.

Бүдүүвч 1



Хөгжингүй орнуудад итгэлийн түвшинг хэмжих зорилготой төрийн болоод төрийн бус байгууллагуудын хийсэн судалгаанууд маш олон байдаг.


Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт, Евробарометр, Азийн барометр, Латинбарометр, Австралийн Засгийн Газрын Мэдээллийн Менежментийн Алба, MORI, BBC and Gallup International, НҮБ-ын Олон нийтийн харилцах алба ба Санхүүгийн Онлайн Сүлжээ, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Transparency International, бусад үндэсний хэмжээний болон олон улсын хэмжээний олон байгууллагууд дэлхийн янз бүрийн хэсгүүдэд явуулсан судалгаанууд итгэл буурч байгааг баталсан байна.

Олон нийт төр засагт ерөнхийд нь бага итгэдэг болох нь судалгаанаас харагдаж байна. Гэхдээ олон нийтийн институтуудад итгэх итгэлд нөлөөлөгч эдийн засгийн, нийгмийн, улс төрийн хүчин зүйлсэд төрийн захиргааны аль түвшний байгууллага үүрэг хариуцлага хүлээх ёстой талаарх бодол хоорондоо янз бүрээр байж болох тул орон нутаг бүр, муж бүр, холбооны засагт тус бүр итгэх хүмүүсийн итгэл адилгүй байж болно. Ийм ялгааг судлахаар дараах асуултыг тавьжээ: “Төрийн захиргааны дараах шатны байгууллагад та итгэж болно гэж хэр их боддог вэ? Үргэлж үү, ихэнхдээ юу, заримдаа юу, хааяадаа л уу, мэдэхгүй юу?”

Бүдүүвч 2-т үзүүлсэн хариунууд төр засгийн өөр өөр түвшний институтад итгэх итгэл нэлээд ялгаатай байгааг харуулж байна. Жишээлбэл олон нийтийн 45% нь холбооны засагт заримдаа л итгэж болно гэсэн байгаа бол мужийн түвшинд “заримдаа л” гэдэг хариу 30%, орон нутгийн түвшинд 25% байна.

Бүдүүвч 2

Төр засгийн өөр өөр түвшний институтэд итгэх итгэл




Төрийн захиргааны өөр өөр түвшний байгууллагуудад итгэх олон нийтийн итгэлийг өөр хэмжүүрээр хэмжих зорилгоор дээрх судалгааны хүрээнд төрийн захиргааны өөр өөр түвшний байгууллагууд тус бүр олон нийтийн саналд хэр хариу өгч, арга хэмжээ авдаг талаар хүмүүсийн саналыг асуужээ. Судалгааны асуулт нь "Төр засгийн өөр өөр түвшний байгууллагууд олон нийтийн саналд хариу арга хэмжээ авдаг эсэх талаар та санал нийлж байна уу, нийлэхгүй байна уу, маш ихээр санал нийлж байна уу, маш ихээр санал нийлэхгүй байна уу, санал нийлэх ч үгүй, санал нийлэхгүй ч үгүй байна уу гэдэгт та хариулна уу".

Олон нийтийн саналд хэр хариу өгч арга хэмжээ авдаг талаар асуухад хүмүүс дээд түвшний захиргааны байгууллагуудад доодыг бодвол итгэх нь бага байдаг байна (Figure 5-ыг үз). Холбооны засгийн хувьд түүнийг олон нийтийн саналд хариу арга хэмжээ үзүүлж чаддаг гэдэгтэй олон нийтийн дийлэнх нь (60% нь) санал нийлэхгүй буюу маш ихээр санал нийлэхгүй байгаа ажээ. 27% нь үүнтэй санал нийлэх ч биш нийлэхгүй ч биш байхад ердөө бага хувь нь (12%) санал нийлж, 1% нь маш ихээр санал нийлж байгаа ажээ.

Бүдүүвч 3

Төр засгийн өөр өөр түвшний байгууллагууд олон нийтийн саналд хариу арга хэмжээ авдаг байдал



Мужийн засаг нь холбооны засгийг бодвол олон нийтийн саналд хариу арга хэмжээ үзүүлэхдээ сайн гэж үзэгджээ. Түүнийг олон нийтийн саналд хариу арга хэмжээ үзүүлдэг гэж 29% нь санал нийлж, 2% нь маш ихээр санал нийлжээ. Хамгийн олон өгсөн хариулт нь "санал нийлэх ч үгүй, санал нийлэхгүй ч үгүй" гэсэн хариу (35%) байна. 34% нь санал нийлэхгүй, харин 8% нь санал маш ихээр санал нийлжээ. Эцэст нь, орон нутгийн засгийг хамгийн таатайгаар үзсэн байна. Түүнийг олон нийтийн саналд хариу арга хэмжээ үзүүлдэг гэдэгтэй олон нийтийн нэлээд бага хувь нь (19%) санал нийлэхгүй, 6% нь маш ихээр санал нийлэхгүй гэсэн бол бараг хагас нь (40%) санал нийлж, 8% нь маш ихээр санал нийлжээ. 29% нь санал нийлэх ч үгүй, нийлэхгүй ч үгүй байв.

Дэлхийн хэмжээнд төр засагт сэтгэл хангалуун биш байх үзэгдэл 2005 онд Баруун Европт 65%, Зүүн болон Төв Европт 73%, Хойд Америкт 60%, Африкт 61%, Ази Номхон Далайд 65%, Латин Америкт 69% тус тус байв. Дальтон дэлхийн янз бүрийн улс орнуудад итгэлийн түвшинг цаг хугацааны янз бүрийн үеүдэд ямар байсныг шинжилж үзээд улс төрийн институциуд болон улс төрийн лидерүүдэд үзүүлэх итгэл Недерландаас бусад орнуудад тогтмол буурч ирж байсныг илрүүлсэн. Австри, Их Британи, Финланд, Норвейг, Швед улсуудад улс төрчдийг санал авахаас өөр юманд санаа тавьдаггүй гэж үзэх нь улам улам нэмэгдэж байна. Канад, Дани, Герман, Франц, Итали, Шинэ Зеланд, Австрали улсуудад сонгогдсон төлөөллүүд нь олон нийттэй холбоо харилцаагаа таслаж, санаа тавихаа больж байна гэж хүмүүс үздэг ажээ. Төр засгийн институциуд болон төлөөллүүдэд итгэх итгэл буурч байгаа бүс нутгуудыг хамарсан энэ хандлага 1970-аад онуудаас 1990-ээд онуудын дунд үе хүртэлх цаг хугацааг хамарч байгаа юм (Dalton 2005).

Улс төрийн итгэл яагаад буурч ирсэн бэ? Өндөр хөгжилтэй, аж үйлдвэржсэн, ардчилсан орнууд дахь "ардчиллын доройтол" гэж нэрийддэг энэхүү итгэл буурах

үзэгдлийн шинж тэмдгүүд нь сонгуульд оролцогчдын тоо буурсан, залуус улс төрд сонирхолгүй болсон, иргэний оролцооны түвшин буурсан зэрэг үзүүлэлтүүд юм. Шинж тэмдэг гэдэг зүйл итгэл буурах болсон шалтгааныг тайлбарлах тайлбар болохгүй хэдий ч байж болох олон шалтгаануудыг энд иш татаж болох байна. Эдийн засгийн байдал үе үе доройтон, төр засгийг мөнгөний болон санхүүгийн хүнд сорилтуудыг давж чадахгүй байгаад байна гэсэн бодол иргэдэд бий болох нь нэг шалтгаан болно. Итгэлийн түвшин өндөр байх явдал хөрөнгө чинээлэг газруудад байдаг гэж улс төрийн эдийн засгийн ном зохиолуудад санал нэгтэй бичсэн байдаг. Эргээд нөгөө талд ядуу дорой газруудад итгэл бага түвшинд байдаг. Эдийн засгийн өсөлт гаргаж, ажлын байрууд бий болгож, боловсролыг хүртээлтэй болгож, үйлчилгээг амархан, ил тод байдлаар хүргэж чаддаг төр засагт хүмүүс илүү итгэдэг.

Дэлхий дээр итгэл буурч байгаад нөлөөлөгч хүчин зүйлсүүд дан ганц эдийн засгийн шалтгаанууд биш байна. Улс төрийн жигшүүрт хэргүүд, авилгал хээл хахууль, тэгээд мөн эдгээр асуудалд хэвлэл мэдээллийнхэн заримдаа хэтэрхий их анхаарлыг татаж буй явдал зэрэг нь төр засгийн институциуд болон улс төрийн лидерүүдэд итгэх итгэлийг буурахад тодорхой хэмжээгээр нөлөөлдөг. Эспинал, Хартлин нар үзэхдээ аж үйлдвэржсэн орнуудыг бодвол хөгжиж буй орнуудад төр засагт итгэхэд аюулгүй байдал болон авилгал хоёр хамаагүй илүү чухал гэсэн бол харин аюулгүй байдал, авилгалын асуудлууд дээр явуулж буй улс төрийн үйл ажиллагаа аль ч газарт итгэлийг нэмэгдүүлдэг байна (Espinal, R. and J.Hartlyn 2006).

Нас, орлогын түвшин гэх мэт нийгэм, хүн ам зүйн үзүүлэлтүүдээс гадна нийгмийн капитал ба ба иргэний идэвхи зэрэг ерөнхийд нь хамруулж үздэг хэмжүүрүүд төр засагт итгэх улс төрийн итгэлийн түвшинд нөлөөлдөг нийгмийн чухал хүчин зүйлс юм.


Төр засагт болон тэнд байгаа төлөөллүүдэд итгэх итгэл сайн засаглалыг хөхүүлдэг бол сайн засаглал нь эргээд итгэлийг бүх хэлбэрээр нь бий болгож батжуулдаг. Нийгмийн болон улс төрийн итгэлийн тухай үзэл санааны онолын тулгуур болон практик хэрэглээг сайн засаглалтай холбон нарийн шалгаад үзэхэд улс төрийн лидерүүд дараах стратегиудыг хэрэгжүүлснээр итгэлийг бүрдүүлж хадгалж болох нь харагддаг.

Дээрх харьцуулсан судалгааны үр дүнгээс харахад, олон нийт төр засагт ерөнхийд нь итгэх итгэл муутай байдаг ажээ. Түүнчлэн, олон нийт төрийн захиргааны дээд түвшний байгууллагуудад доод түвшнийг бодвол бага итгэдэг ажээ. Итгэлтэй холбоотойгоор ч тэр, олон нийтийн саналд хариу арга хэмжээ үзүүлэхтэй холбоотойгоор ч тэр, олон нийт нь орон нутгийн төрийн захиргааны байгууллагад тодорхой хэмжээгээр итгэн, харин төрийн төв буюу дээд шатны байгууллагын талаар харьцангуй сөрөг санаа бодолтой байдаг байна.

Монгол дахь олон нийтийн улс төрийн итгэл ямар байна вэ?


Азийн судалгааны төвийн санхүүжилтээр хийгдсэн улс төрийн итгэлийн талаарх олон нийтийн санаа бодлын түүвэр судалгааг явуулахдаа судалгаанд оролцогчдын хүйсийн тэнцвэртэй байдлыг харгалзсан бөгөөд насны хувьд залуучуудыг түлхүү хамруулахыг зорьсон. Судалгааны зорилго, шаардлагатай холбоотойгоор тодорхой түвшний боловсрол эзэмшсэн иргэдийг түүвэрлэн сонгосон (Бүдүүвч 4).

Бүдүүвч 4. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал




Судалгаанд оролцогчдын эдийн засгийн байдлыг орлогын түвшин ба амьдарч буй орон байрны хувьд харьцуулан авч үзсэн. Орлогын түвшний хувьд 4% нь л өндөр хэмжээний орлоготой гэсэн бол үлдсэн 94% нь бага болон дунд орлоготой гэж хариулжээ (Бүдүүвч 5). Харин орон байрны нөхцлийн хувьд 57% нь өөрийн эзэмшлийн сууцанд амьдардаг гэсэн бол үлдсэн 43% нь түрээсийн сууцанд амьдардаг гэж хариулсан (Бүдүүвч 6).

Бүдүүвч 5. Орлогын түвшин




Бүдүүвч 6. Орон байрны нөхцөл



Шашин шүтдэггүй иргэд 22%-ийг эзэлж байгаа бол, 68% нь буддын шашныг, 5% нь бөөгийн шашныг, 3% нь исламын шашныг, үлдсэн 2% нь христийн шашныг шүтдэг гэсэн байна (Бүдүүвч 7).

Бүдүүвч 7. Шашин шүтлэг




Судалгааны үндсэн асуулт нь “Та дараах зүйлсэд хэр зэрэг сэтгэл хангалуун байдаг вэ?”, “Та дараах байгууллагуудад хэр зэрэг итгэдэг вэ?” гэсэн хоёр хэсгээс бүрдэж байгаа болно.

Судалгаанд оролцогчид гэр бүл (95%), найз нөхөд (93%), эзэмшсэн боловсрол (89%), өөрийн эрүүл мэндийн асуудал (87%), амьжиргааны түвшин (84%), оршин


суугаа орон байр (82%), чөлөөт цаг (79%), өрхийн орлого (77%), хөрш (58%), эрхэлж буй ажил (46%) зэрэг хувь хүнтэй илүү ойр дотно байдаг асуудлуудад их сэтгэл хангалуун байдаг ажээ. Харин нийгмийн дэг журам (70%), хүрээлэн буй орчин (64%), нийгмийн халамжийн систем (63%), ардчилсан улс төрийн систем (51%) зэрэг асуудлуудад судалгаанд оролцогчдын сэтгэл хангалуун байдал нь бага зэрэг, огт үгүй, мэдэхгүй гэж хариулсан хариултын хувь өндөр байна. Энэ нь гэр бүл найз нөхөд зэрэг бодит зүйлсээс ялгаатай, илүү нийгэмтэй холбоотой асуудлуудад хандах иргэдийн сэтгэл ханамжийн байдал илт бага байгааг харуулж байгаа юм (Бүдүүвч 8).

Бүдүүвч 8. Та дараах зүйлсэд хэр зэрэг сэтгэл хангалуун байдаг вэ?



Бүдүүвч 9.а.-аас харахад, судалгаанд оролцогчид улс төрийн нам (71%), Улсын Их Хурал (66%), цагдаа (61%), шүүх (68%), зэвсэгт хүчин (68%), орон нутгийн удирдлага (67%), засгийн газар (61%) зэрэг байгууллагуудад бага зэрэг итгэдэг, огт итгэдэггүй, мэдэхгүй гэж хариулсан хувь нь "их, дунд зэрэг итгэдэг" гэж хариулсан хувиас харьцангуй их байна. Эрүүл мэндийн (2%) болон боловсролын (2%) систем, төрийн бус байгууллагууд (3%), хэвлэл мэдээллийн байгууллага (8%), үйлдвэрчний эвлэл (2%), банк санхүүгийн байгууллага (3%), олон улсын байгууллагуудад (26%) "маш их итгэдэг" гэж хариулсан иргэд тодорхой хэмжээгээр байсан бол төр засгийн буюу улс төрийн байгууллагуудад нэг ч респондент санал өгөөгүй.

Бүдүүвч 9.а. Та дараах байгууллагуудад хэр зэрэг итгэдэг вэ?



Энэхүү судалгааны дүнгээс харахад иргэдийн 4% нь улс төрийн намуудад их итгэдэг, 61% нь намуудад дунд зэрэг, бага итгэдэг гэсэн бол итгэдэггүй гэж судалгаанд оролцогчдын 30% хариулсан байгаа нь намууд болон нэр дэвшигчид Үндсэн хуульд заасны дагуу ард түмний элч байх үүргээ биелүүлэхгүй, хувийн эрх ашиг хөөцөлдөж байгааг харуулж байна. Улсын Их Хурал (66%), засгийн газар


(61%), орон нутгийн удирдлагад (67%) бага зэрэг итгэдэг, огт итгэдэггүй, мэдэхгүй гэсэн хариулт 61-67%-ийг эзэлж байгаа нь төр засгийн байгууллагуудын баталж буй хууль, явуулж буй бодлого шийдвэр иргэдийн амьдралд сайнаар нөлөөлөхгүй байгааг харуулж байна.

ХБНГУ (76%-аас 77% болж өссөн), Финлянд (73%-аас 75% болж өссөн), Люксембург (54%-аас 57% болж өссөн), Нидерланд (65%-аас 67% болж өссөн), Испани (28%-аас 37% болж өссөн) зэрэг улсуудын иргэд шүүх засаглалдаа итгэх итгэл 2002 оноос 2004 онуудад бага хэмжээгээр нэмэгдэж байжээ (Gabriel, Oscar W. and Sonja Zmerli 2006: 11). Харин Монгол улсын хувьд судалгаанд оролцогчдын 2% нь шүүх засаглалд их итгэдэг, 59% нь дунд, бага зэрэг итгэдэг гэсэн бол 33% нь огт итгэдэггүй гэж хариулсан нь судалгаанд зориулж бэлтгэсэн нийт асуултуудаас "огт итгэдэггүй" хариулт дээр хамгийн их санал авсан хариулт байлаа. Монгол улсад төрийн болон төрийн бус байгууллагын албан тушаалтан, иргэн хэн ч байсан аль ч түвшний шүүхээр хэрэг шийдвэрлүүлэхэд тэгш эрхтэй байна гэж Монгол улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуульд зааж өгсөн байдаг. Гэтэл өнөөдөр шүүхийн байгууллага хэн мөнгөтэй, эрх мэдэлтэй хүний талд үйлчлэх хандлага бий боллоо гэж судлаачид үздэг. "Хууль шүүхийн байгууллагаар өөрт тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхэд зардал их гардаг, цаг их авдаг, танил талгүй бол бүтдэггүй, асуудлыг шударга шийддэггүй, хүнд суртал ихтэй" (ШУА-ийн Философи, Социологи, Эрхийн Хүрээлэн 2008: 17) гэсэн нийтлэг бэрхшээлийг иргэд нэрлэдэг байна. "Шүүх хөрөнгө мөнгө, эрх мэдэлтэйд илүү үйлчилдэг (45,4%), шүүхийн шийдвэрт албан тушаалтнууд нөлөөлдөг (41,2%), төрийн эрх ашигт үйлчилдэг (47,7%) гэж судалгаагаар гарсан" (ШУА-ийн Философи, Социологи, Эрхийн Хүрээлэн 2008: 17) нь иргэд шүүх засаглалд итгэхгүй байх үндсэн шалтгаан болж байна.

Үүнийг Австралийн жишээн дээрх харьцуулан үзвэл, австраличуудын "маш их" итгэл үзүүлдэг байгууллагуудыг харвал телевиз (2%), сонин хэвлэл (1%), засгийн газар (13%), шүүх тогтолцоо (5%), улс төрийн намууд (2%), банк санхүүгийн байгууллагууд (2%), парламент (5%) зэрэгт итгэх итгэлээсээ илүү цагдаа (13), зэвсэгт хүчиндээ (26%) итгэх итгэл хамгийн өндөр байдаг байна (Bean 2003: 15). Энэ дүнг өөрийн улстай харьцуулбал цагдаад 7%-тай, зэвсэгт хүчинд 10%-тай байна. Монгол улсын цагдаа болон зэвсэгт хүчний талаарх мэдээлэл иргэдэд төдийгүй судлаачдад хаалттай байдаг нь үүнтэй холбоотой.

Монгол улсад эрүүл мэндийн салбарын техник технологийн шинэчлэл муу хийгддэг, зарим шаардлагатай үзлэг, оношлогоо, хагалгааг хийх эмч мэргэжилтэн дутмаг байдгаас шалтгаалан ихэнх хүнд өвчтэй хүмүүс гадаад руу их өндөр төлбөр төлөн эмчлүүлдэг. Мөн манай улсын эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд эрүүл мэндийн даатгалаа бүрэн төлж байсан ч ашиглаагүй удсан иргэн нэг жил эрүүл мэндийн даатгал төлж байгаа иргэнтэй адил хэмжээний үйлчилгээ авдаг зэрэг дутагдалтай талууд байсаар байна. Бүдүүвч 9.б.-с нийгмийн институтуудад олон нийтийн итгэл ямар түвшинд байгааг харж болно. Судалгаанд оролцогчдоос "Та эрүүл мэндийн системд итгэдэг үү?" гэсэн асуулт тавихад 9% нь их итгэдэг, 39% нь дунд зэрэг итгэдэг, 34% нь бага зэрэг итгэдэг гэсэн бол 12% нь огт итгэдэггүй гэж хариулсан.

Бүдүүвч 9.6. Та дараах байгууллагуудад хэр зэрэг итгэдэг вэ?



Монгол улсад боловсролын салбарын харилцааг Боловсролын тухай, бага дунд боловсролын тухай, дээд боловсролын тухай, мэргэжлийн боловсролын тухай зэрэг хууль тогтоомжоор зохицуулдаг. Төрөөс бүрэн дунд боловсролыг дэлхийн жишигт нийцүүлж 12 жилийн сургалттай болгохоор арга хэмжээнүүд авч ажиллаж байгаа. Сүүлийн жилүүдэд ажлын байрны хэрэгцээ шаардлагыг үндэслэн техник технологийн салбараар суралцагсдыг илүүтэй дэмжих болсон. Мэргэжил сургалтын төвүүдийг нийслэл болон хөдөө орон нутагт ихээр байгуулж төрөөс дэмжлэг үзүүлэх бодлого баримталж байгаа. Судалгаанд оролцогчид боловсролын системд 15% нь их итгэдэг, 49% нь дунд зэрэг итгэдэг, 25% нь бага зэрэг итгэдэг, 9% нь огт итгэдэггүй гэсэн бол 2% нь мэдэхгүй байна гэж хариулжээ. Судалгаанд зориулж бэлтгэсэн нийт асуултуудаас “итгэдэг” гэсэн хариултыг хамгийн өндөр хувь авсан асуулт болсон юм.


Төрийн бус байгууллагууд “огт итгэдэггүй” гэсэн хариултыг нийт бэлтгэсэн асуултуудаас хамгийн бага хувь буюу 5%-ийг авсан нь иргэд төрийн бус байгууллагуудын явуулж буй бодлого, үйл ажиллагааг дэмждэг нь харагдаж байна.

Иргэд төрийн үйл ажиллагаа, хууль эрх зүй, төрийн байгууллагуудтай холбоотой мэдээллийг төр засгийн албан ёсны эх сурвалжаас өөрсдөө олж авах явдал ихэнх тохиолдолд гардаггүй, харин ч хэвлэл мэдээллийн хэрэгслээс олж мэдэх боломж ихэссэн. Австралид 2001 оны судалгаагаар нийт судалгаанд оролцогчдын 26% нь телевизэд итгэх итгэл их гэж хариулсан бол 56% нь нэг их итгэдэггүй гэж хариулсан. Сонин хэвлэлд итгэдэг үү гэсэн асуултанд Австрали

респондентуудын 18% нь их итгэдэг, 56% нь нэг их итгэдэггүй гэсэн. Харин манай улсын хувьд судалгаанд оролцогчдын ихэнх нь телевиз, сонин хэвлэлд итгэх итгэл их байгааг харуулж байна. Энэ нь нэг талаараа иргэд төр засгийн шийдвэр, үйл ажиллагааны тухай мэдээллийг олж авахад цагаа алдаж, хүнд сурталтай тулгардаг гэсэн нийтлэг хандлага байдагтай холбоотой болов уу.

Үйлдвэрчний эвлэлд итгэх итгэл 16% нь сайн гэж хариулсан бол 66% нь дунд, бага итгэдэг, 8% нь огт итгэдэггүй гэсэн бол 9% нь мэдэхгүй гэж хариулжээ. Иргэд банк санхүүгийн байгууллагад итгэх итгэл 78%-тай байгаа бол, томоохон компаниудад итгэх итгэл 77%-тай байна. Харин Австралын хувьд судалгаанд оролцогчид банк санхүүгийн байгууллагууд (68%), томоохон компаниуддаа (90%) нь их итгэдэг байна.

Бүдүүвч 9.в. Та дараах байгууллагуудад хэр зэрэг итгэдэг вэ?



Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүн сүүлийн жилүүдэд тасралтгүй өсч байгаа бөгөөд энэ нь уул уурхай, аж үйлдвэр, барилга угсралт, тээвэр холбоо, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээний салбарын өсөлттэй шууд холбоотой. Мөн манай улсад олон улсын байгууллагуудын болон гадаад орнуудын тусламж дэмжлэг ихээр орж ирдэг. Ялангуяа Олон Улсын Валютын сан, Дэлхийн Банк, Дэлхийн Худалдааны байгууллага зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламж дэмжлэг ихээр орж ирэх болсон. Сүүлийн жилүүдэд Монгол улсын Засгийн газраас гадаад улсуудаас авч буй зээлийн хэмжээг бууруулж, хандив, буцалтгүй тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримтлах болсон. Судалгаанд оролцогчид Олон Улсын Валютын сан (42%), Дэлхийн Банк (41%), Дэлхийн Худалдааны байгууллагад (46%) итгэдэг гэж үзсэн бол 9-18% нь дээрх

байгууллагуудад бага зэрэг итгэдэг гэж хариулсан байна (Бүдүүвч 9.в.). Харин судалгаанд оролцогчдын ихэнх (21-31%) хэсэг нь эдгээр олон улсын санхүүгийн байгууллагуудад итгэдэг үү гэсэн асуултанд "мэдэхгүй" гэж хариулсан нь энэ талаарх мэдээ мэдээлэл дутмаг, хомс байдагтай холбоотой байж болох юм. Та Нэгдсэн Үндэстний Байгууллагад хир зэрэг итгэдэг вэ? гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 72% нь итгэдэг, 9% нь бага зэрэг итгэдэг, 21% нь мэдэхгүй гэж хариулсан. Монгол улс ба НҮБ-ын хамтын ажиллагаа нь Монгол улсын аюулгүй байдлыг бэхжүүлэх, ядуурлыг бууруулах, нийгэм эдийн засгийн хөгжлийг хангах зэрэг асуудлуудаар амжилттай хэрэгжиж байгаа. Монгол улс 2002 оноос хойш НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэргийн багуудаа явуулсан зэрэг нь монголчуудын НҮБ-д хандах эерэг хандлагыг илэрхийлж байгааг судалгааны дүн харууллаа.

Судалгааны үр дүнд ашигласан ном, зохиолууд

- Almond, G.A and S. Verba. *The Civic Culture: Political Attitudes and Democracy in Five Nations*. Princeton: Princeton University Press, 1963
- Bean, Clive. *Citizen Confidence in Social and Political Institutions in a Changing World*, paper presented to the Social Change in the 21st Century Conference, Centre for Social Change Research, Queensland University of Technology, 21 November 2003
- Bok, D. "Measuring the Performance of Government: in *Why People Don't Trust Government?* J., 1997
- Braithwaite, J. "Institutionalizing Distrust, Enculturating Trust," in *Trust and Governance*. J. Braithwaite and M. Levi (eds.) New York: Russell Sage Foundation, 1998
- Dalton, Russell J. "The Social Transformation of Trust in Government," *International Review of Sociology* 15, 1 (March 2005): 133-54.
- Duck, S. *The Handbook of Personal Relationships: Theory, Research and Interventions*. New York: Wiley, 1997
- Dunn, J. "Trust and Political Agency," in *Trust: The Making and the Breaking of the Cooperative Bond*. D. Gambetta (ed.) Oxford: Basil Blackwell, 1988
- Espinal, R. and J. Hartlyn. "Performance Still Matters Explaining Trust in Government in the Dominican Republic," *Comparative Political Studies* 39, 2 (March 2006): 200-23.
- Finifter, A.W. "Dimensions of Political Alienation," *American Political Science Review* 64, 2 (June 1970)
- Fukuyama, F. *The Social Virtues and the Creation of Prosperity*. New York: Free Press, 1995
- Gabriel, Oscar W. and Sonja Zmerli, *Politisches Vertrauen: Deutschland in Europa*, in: *Aus Politik und Zeitgeschichte*, No. 30-31/2006
- Hetherington, M.J. *Why Trust Matters: Declining Political Trust and the Demise of American Liberalism*. Princeton: Princeton University Press, 2005
- Kramer, R.M. and T. R. Taylor. *Trust in Organizations: Frontiers of Theory and Research*. Thousand Oaks, Calif.: Sage, 1995
- Miller, A. H. and O. Lijsthaug. "Political Parties and Confidence in Government: A Comparison of Norway, Sweden and the United States," *British Journal of Political Science* 20, 3 (July 1990)
- Miller, A. H. "Political Issues and Trust in Government, 1964-1970," *American Political Science Review* 68, 3 (September 1974)

Newton, K. and P. Norris. "Confidence in Public Institutions: Faith, Culture, or Performance?" in *Disaffected Democracies: What's troubling the Trilateral Democracies?* S. J. Pharr and R.D. Putnam (eds.) New Jersey: Princeton University Press, 2000

Seligman, A. *The Problem of Trust*. Princeton: Princeton University Press, 1997

Sztompka, P. *Trust: A Sociological Theory*. Cambridge: Cambridge University Press, 1999

Tarrow, S. "Mad Cows and Activists: Contentious Politics in the Trilateral Democracies," in *Disaffected Democracies: What is Troubling the Trilateral Democracies?* S. Pharr and R. Putnam (eds.) Princeton: Princeton University Press, 2000

Thompson, D. F. *Restoring Responsibility: Ethics in Government, Business and Healthcare*. Cambridge: Cambridge University Press, 2004

Veenstra, G. "Explicating Social Capital: Trust and Participation in the Civil Space," *Canadian Journal of Sociology* 27, 4 (Autumn 2002)

Wheless, L.R. and Grotz J. "The Measurement of Trust and Its Relationship to Self-Disclosure," *Human Communication Research* 3, 3 (March 1977)

МУШУА. Философи, социологи, эрхийн хүрээлэн, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр. *Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт 2007-2008*. УБ., 2008

Abstract

In western and some other advanced democratic systems, public trust in government has been declining since the 1960s. A large body of social science literature now supports this conclusion, generally focusing on one of two areas. In our research these are also considered as one of basic parts of methodology.

The first group of studies suggests that public trust in government is a function of economic factors, social conditions such as crime and poverty, and political factors including scandals and job performance evaluations of elected officials and government institutions. A second line of research has found that trust in government helps to explain other political attitudes and behaviors. For example, declining levels of trust affect public evaluations of government, and vote intentions. Moreover, we should note that most of those research conducted by international scholars and research centers are mainly concerned on public trust or confidence issues on government and government institutions.

Therefore, one of our research peculiarities is to cover not only government institutions but also other political institutions and we gave importance to comparative research and making integrated analyze on public confidence in those political institutions.